



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ

АУДИТЫН КОД: УВА-2025/07-19/-ШТА-НА/

Улаангом хот 2025 он

Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь
Утас: 70453317 Цахим хаяг: batsuurim@audit.gov.mn
Аудитын менежер М.Бат-Амгалан
Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор Т.Намжил
Цахим хаяг: namjilt@audit.gov.mn
Ахлах аудитор Ч.Мөнхтогтох
Цахим хаяг: munkhtogtokhch@audit.gov.mn
Аудитор Т.Амармэнд
Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn
Аудитор Т.Золоо
Цахим хаяг: zoloot@audit.gov.mn
Аудитор Б.Нямбуу
Цахим хаяг: nyambuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
Орн. audit.mn хаягаар авна уу.



Агуулга 3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл4-5

Товчилсон үгийн тайлал.....6

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....7

НЭГ. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН 65 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ УРТ, ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТТАЙ УЯЛДСАН Ч, 13 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ АЙМГИЙН 2026 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ТУСГАГДААГҮЙ БАЙНА.....8-9

ХОЁР. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ.....10

Санал: 1. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийн суурь орлогыг Сангийн яамнаас 33,168.7 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг 8,483.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 41,652.6 сая төгрөгөөр тусгасныг дэмжиж байна..... 10-11

ГУРАВ. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ.....12

Санал: 1. Аймгийн төсвийн хөрөнгөөр 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засвар, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан Мал угаалын ванн /Наранбулаг сум/-50.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хасаж төсвийн зардал бууруулах боломж байна.....12-13

Санал: 2. Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг Замын сангийн эх үүсвэрт давхардуулан тусгасныг аль нэг эх үүсвэрээс хасаж төсвийн зардал бууруулах боломж байна13

Санал: 3. Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд батлагдсан зураг төсөвгүй, ТЭЗҮ, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт байхгүй, холбогдох зөвшөөрөл дутуу, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 29 төсөл, арга хэмжээг нийт 2,219.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.....14-15

Санал: 4. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийн хөтөлбөр төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан 1 төсөл, арга хэмжээний хөтөлбөр нь байхгүй байна..... 16



Санал: 5. Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын шинж чанартай Шинэ Улаангом захын барилгад дэмжлэг- 3,000.0 сая төгрөгийг урсгал зардлаар тусгасан байна. 16

ДӨРӨВ. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ17

Санал 1: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Бизнес инкубатор төвийн барилгыг зориулалтын дагуу ашиглах замаар орон нутгийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.....17-18

Санал:2. Улсын төсвийн байгууллагуудын торгуулийн орлого Улсын төсөвт төвлөрч байгаа нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь заалттай нийцэхгүй байгаа асуудлыг шийдвэрлүүлэхээр салбар яаманд санал уламжилснаар орон нутгийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна..... 18-19

ДҮГНЭЛТ.....20



Аудит хийх
үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ын дагуу Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэсэн. Үүнд:

- Төсвийн төсөл нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэх;
- Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх боломж байгаа эсэх;
- Орон нутгийн төсвийн төсөлд тусгасан зардлыг бууруулах боломж байгаа эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх боломж байгаа эсэх;

Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817-1:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт өгөх аргачлал”, бусад заавар, аргачлалыг мөрдөж ажиллав.

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын гол шалгуур үзүүлэлтээр эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Татварын багц хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэр, нэгж түүний удирдлагын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль



**Аудитын хамарсан
Хүрээ**

- Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Холбогдох бусад хууль, журам, заавар

Аудитад аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Татварын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар болон холбогдох бусад газруудыг хамрууллаа.

**Аудитын бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Намжил, Ч.Мөнхтогтох, аудитор Т.Золоо, Т.Амармэнд, Б.Нямбуу, Т.Ариунсайхан, Л.Шагдарсүрэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үзүүлэлт
ИЗХОТАХ	Их засвар, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтад "... Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх" гэж заасны дагуу Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд аудит хийж Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал, дүгнэлтийг боловсрууллаа.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл, 2027, 2028 оны төсвийн төсөөллийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс Сангийн яамны Fiscal B программд шивж оруулан, Орон нутгийн 2024 оны төсвийн гүйцэтгэл, 2026 оны төсвийн төслийг аймгийн Засаг даргын орлогчийн 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 2/1834 дүгээр албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг УИХ-ын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан байна.

Монгол улсын 2026 оны Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарч ажиллах чиглэлийг Сангийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/10180 дугаар бичгээр ирүүлсэн байна. Үүнд:

- Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж
- Орон нутгийн 2026 оны суурь орлого, зарлага, санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого
- Орон нутгийн 2026 оны хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тооцоо

Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь хууль, журамд заасны дагуу Орон нутгийн 2026 оны төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар бодитой хэрэгжих боломжтой дараах саналуудыг дэвшүүлж байна.



БҮЛЭГ: 1 Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан 65 төсөл, арга хэмжээ урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримттай уялдсан ч, 13 төсөл, арга хэмжээ нь аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгагдаагүй байна.

Увс аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050”, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан байна.

Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах хөрөнгө оруулалтын болон бусад төсөл, арга хэмжээний санал ирүүлэх тухай аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 1/2244 дүгээр албан бичгийг аймгийн ИТХ-ын ажлын алба, сумдын Засаг дарга, агентлаг, байгууллагуудад хүргүүлсэн байна. Энэ хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сум, байгууллага, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэн эрэмбэлж тусгасан байна. Ингэхдээ хөрөнгө оруулалт, засвар, тоног төхөөрөмжтэй холбоотой нийт ирүүлсэн саналыг эрэмбэлж, 2026 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж Эдийн засаг, хөгжлийн яаманд аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/140 дүгээр албан бичгээр хүргүүлсэн байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг даргын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг”, 9.10.1 дэх заалтад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна”, 6.10.4 дэх заалтад “Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасны дагуу Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тулгуурлан боловсруулсан байна.

Увс аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тусгаагүй болно.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгахаар боловсруулсан хөтөлбөр, арга хэмжээ нь орон нутгийн төсөвт дараах байдлаар тусгагдсан байна.



№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ		Аймгийн 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээ	
	Санхүүжүүлэх эх үүсвэр	Нийт хөтөлбөр төсөл, арга хэмжээний тоо	Тусгагдсан хөтөлбөр төсөл, арга хэмжээний тоо	Тусгаагдаагүй хөтөлбөр төсөл, арга хэмжээний тоо
1	Орон нутгийн хөгжлийн сан	21	16	5
2	Их засвар хөрөнгө оруулалт	22	16	6
3	Замын сангийн хөрөнгө оруулалт	5	4	1
4	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	2	2	
5	Хөтөлбөр төсөл, арга хэмжээ	15	14	1
Нийт		65	52	13

Эх сурвалж: Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл, аймгийн 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 онд хэрэгжүүлэх 65 төсөл, арга хэмжээнээс 52 төсөл, арга хэмжээ нь аймгийн 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан, 13 төсөл, арга хэмжээ нь тусгаагдаагүй байна. Үүнд: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 5, их засвар, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ 6, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ 1, Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 1, нийт 13 хөтөлбөр төсөл, арга хэмжээ байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 онд хэрэгжүүлэх 65 хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй дараах байдлаар уялдсан байна.

№	Аймгийг Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр		Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан
	Бодлого	Ерөнхий хөтөлбөрийн тоо	
1	Бүсчилсэн хөгжлийн бодлого	3	12
2	Хүний хөгжлийн бодлого	6	30
3	Эдийн засгийн хөгжил	8	15
4	Засаглалын бодлого	4	8
Дүн		21	65

Эх сурвалж: Аймгийг Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр



БҮЛЭГ: 2. ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ

Орон нутгийн 2026 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 89,313.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Дээрх эх үүсвэрийг төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 21.0 сая, орон нутгийн орлогоос 41,652.6 сая, санхүүгийн дэмжлэгээр 34,827.1 сая, урьд оны үлдэгдлээс 299.1 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээс 12,455.4 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 58.5 сая төгрөгөөр бүрдүүлэхээр тооцсон байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төслийн суурь орлогыг Сангийн яамнаас 33,168.7 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг 8,483.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн төсөлд 41,652.6 сая төгрөгөөр тусгасан байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Санал:1. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийн суурь орлогыг Сангийн яамнаас 33,168.7 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг 8,483.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 41,652.6 сая төгрөгөөр тусгасныг дэмжиж байна.

Сангийн яамны ирүүлсэн суурь орлогыг дараах нэр төрлүүдээр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Үүнд:

/мянган.төгрөг/				
№	Төсөвт оруулах орлого	Сангийн яамны суурь тоо	2026 оны төсөв	Зөрүү
1	Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	22,860,000.0	23,260,000.0	400,000.0
2	Үйл ажиллагааны орлого	650,000.0	820,000.0	170,000.0
3	Улсын тэмдэгтийн хураамж	540,000.0	602,465.3	62,465.3
4	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	40,650.0	41,150.0	500.0
5	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	665,240.0	991,849.4	326,609.4
6	Газрын төлбөр	570,000.0	620,000.0	50,000.0
7	Торгуулийн орлого	1,000,000.0	1,600,000.0	600,000.0
8	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,150,000.0	1,250,000.0	100,000.0
9	Дуудлага худалдаа	50,000.0	2,526,874.3	2,476,874.3
10	Бусад орлого	100,000.0	3,150,000.0	3,050,000.0
11	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	50,000.0	300,000.0	250,000.0
12	Газрын зөрчил, төлбөрийн өр барагдуулалтын орлого		1,000,000.0	1,000,000.0
13	Газрын тосны орлого	2,603.7	-	(2,603.7)
	Нийт дүн	27,678,493.7	36,162,339.0	8,483,845.3

Эх сурвалж: Сангийн яамны суурь тоо, Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл



Сангийн яамнаас ирүүлсэн суурь орлогоос 12 нэр төрлийн орлогыг 8,486.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөснөөс дуудлага худалдааг 2,476.9 сая, бусад орлогыг 3,050.0 сая, газрын зөрчил, төлбөрийн өр барагдуулалтын орлогыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь төсвийн орлого бүрэн төвлөрөхгүй байх дараах эрсдэлтэй байна. Үүнд:

- Дуудлага худалдааны 2,476.9 сая төгрөгийн орлого нь аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлагдаад, Засгийн газрын шийдвэр гарч ирсэн үед хэрэгжих зохицуулалттай байна. Түүнчлэн дуудлага худалдаа зохион байгуулахад зарагдахгүй байх эрсдэл байна.
- Бусад орлогын 3,050.0 сая төгрөг нь аймгийн Татварын газрын хяналт шалгалтаар ногдуулсан төлбөрийн авлагын 1,000.0 сая төгрөг, агнуурын дуудлага худалдааны орлогын 1,500.0 сая төгрөг, үлдэгдэл нь нэр заагдаагүй бусад орлого байна. Энэ нь татварын авлага бүрэн барагдахгүй байх, Байгаль орчны яамнаас агнуурын тоо толгой батлагдаж ирээгүй байна.
- Газрын зөрчил, төлбөрийн өр барагдуулалтын орлого 1,000.0 сая төгрөг нь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт урд онуудад үүссэн газрын төлбөрийн авлага байна. Энэ нь өмнөх онуудад үүссэн газрын төлбөрийн авлага бүрэн барагдахгүй байх эрсдэлтэй байна.



БҮЛЭГ: 3. ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ

Орон нутгийн 2026 оны төсвийн нийт зарлагыг 89,313.7 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2025 оноос 12,656.1 сая төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн байна.

Төсвийн нийт зардал өсөхөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,829.6 сая, “Шинэ Улаангом” захын барилгад дэмжлэг 3,000.0 сая, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал 321.9 сая, Орон нутгийн нөөц хөрөнгө 190.3 сая, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал 189.0 сая, Сонгуулийн үр дүнгээр олгох нэг удаагийн тэтгэмж 1,067.2 сая, хөрөнгийн зардал 1,670.2 сая, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 739.8 сая, НДШ-ийн зардал 91.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардал 101.2 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Харин эд хогшил, урсгал засварын зардал 541.1 сая, хангамж, мал эмнэлгийн үйлчилгээ 98.1 сая, махны нөөцийн зардал 200.0 сая, баяр наадмын зардал 105.0 сая, бараа материалын зардал 35.5 сая, дотоод албан томилолтын зардал 38.4 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд урсгал зардал 71,526.8 сая төгрөг буюу 80.1 хувь, хөрөнгийн зардал 17,786.9 сая төгрөг буюу 19.9 хувийг эзэлж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгийн зардлын төлөвлөлтийг эх үүсвэрээр нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 4,680.9 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээ
- Их засвар, хөрөнгө оруулалтын 3,619.1 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ
- Аймгийн Замын сангийн хөрөнгөөр хийгдэх 1,653.9 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ

Түүнчлэн Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дараах хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 68.1 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ
- Хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд 3,855.0 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ

Санал: 1. Аймгийн төсвийн хөрөнгөөр 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засвар, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан Мал угаалын ванн /Наранбулаг сум/-50.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хасах замаар төсвийн зардал бууруулах боломж байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5-д “Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”, 4.5.3-д “Малын эрүүл мэндийг хамгаалах”, 4.5.4-д “Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” гэж заасны дагуу Мал угаалын ванн /Наранбулаг сум/-50.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс шийдвэрлэх бүрэн боломжтой байна.



Учир нь Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгагдсанаар сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн суурь тооцооллыг харахад нийт 7,833.0 сая төгрөгийн орлого хуваарилахаас Наранбулаг суманд 1,521.9 сая төгрөг хуваарилахаар байна. Энэ нь өмнөх онд Наранбулаг суманд хуваарилсан төсвөөс 1,074.2 сая буюу 240 хувиар өссөн, бусад сумдад хуваарилах төсөвтэй харьцуулахад 62.6-849.2 хувиар илүү байна. Өөрөөр хэлбэл зарим сумдаас 8 дахин их төсөв хуваарилагдахаар байна.

Түүнчлэн Наранбулаг суманд өнөөдрийн байдлаар 3 ширхэг мал угаалгын ванн байх бөгөөд тухайн ваннуудыг сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэж байсан байна.

Иймд Аймгийн төсвийн хөрөнгөөр 2026 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засвар, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтаас Мал угаалын ванн /Наранбулаг сум/-50.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хасаж төсвийн зардал бууруулах боломж байна.

Санал: 2. Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг Замын сангийн эх үүсвэрт давхардуулан тусгасныг аль нэг эх үүсвэрээс хасах замаар төсвийн зардал бууруулах боломж байна.

Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ”, 4.1.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй уялдуулан төлөвлөсөн байх” гэж заасан байна.

Гэтэл Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусгасан 2 төсөл, арга хэмжээ нь ижил нэршил, төсөвт өртөгтэйгөөр аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнд давхардаж тусгагдсан байна. Үүнд:

/мянган.төгрөг/				
№	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх/ дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих
1	Тусгай хэрэгцээт иргэдэд ээлтэй явган замын засвар, тоног төхөөрөмж / Улаангом сум /	2026-2026	100,000.0	100,000.0
2	Гэр хорооллын зам засварлах /Улаангом сум 12-р баг/	2026-2026	100,000.0	100,000.0
	Нийт дүн		200,000.0	200,000.0

Эх сурвалж: Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл

Орон нутгийн 2026 оны төсвийн төслийн 2 эх үүсвэрт давхардуулан тусгасан Тусгай хэрэгцээт иргэдэд ээлтэй явган замын засвар, тоног төхөөрөмж /Улаангом сум/-100.0 сая, Гэр хорооллын зам засварлах /Улаангом сум 12-р баг/-100.0 сая төгрөгийн өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг аль нэг эх үүсвэрээс хасах саналтай байна.



Санал: 3. Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд батлагдсан зураг төсөвгүй, ТЭЗҮ, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт байхгүй, холбогдох зөвшөөрөл дутуу, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 2,219.1 сая төгрөгийн 29 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3 дахь заалтад “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”, 13.5 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Аймаг, нийслэлийн түвшинд дараах нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ”, 4.1.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үнэлгээтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх” гэж заасан байхад батлагдсан зураг төсөвгүй, ТЭЗҮ, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт байхгүй, холбогдох зөвшөөрөл дутуу, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 29 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төсөвлөсөн байна. Үүнд:

/мянган.төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Эх үүсвэр	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих дүн
1	2	3	4	5
1	Гэр хорооллын зам засварлах /Улаангом сум 12-р баг/	ОНХС	100,000.0	100,000.0
2	ХХҮГазар ЕБС 4-р сургууль чиглэлийн авто замын холболт /Улаангом сум 4-р баг/	ОНХС	200,000.0	100,000.0
3	Тоглоомын талбай / Улаангом сум 3-р баг/	ОНХС	50,000.0	50,000.0
4	Нийтийн халуун усны барилга дэмжлэг /Өлгий сум/	ОНХС	100,000.0	100,000.0
5	Хог хаягдал тээвэрлэх авто машин авах /Баруунтуруун сум/	ОНХС	50,000.0	50,000.0
6	Эрүүл мэндийн төвийн засвар /Өмнөговь сум/	ОНХС	100,000.0	100,000.0
7	Багийн тохижилт / Улаангом сум 2-р баг /	ОНХС	50,000.0	50,000.0
8	Багийн тохижилт / Улаангом сум 9-р баг /	ОНХС	100,000.0	100,000.0
9	Сумын төвийн хогийн цэгийн нөхөн сэргээлт /Давст сум/	ОНХС	50,000.0	50,000.0
10	Гудамж талбайн гэрэлтүүлэг /Зүүнговь сум/	ОНХС	50,000.0	50,000.0
11	Улаангом сумын 1-р багийн гэрэлтүүлэг	ОНХС	50,000.0	50,000.0



1	2	3	4	5
12	Улаангом сумын газрын хянан баталгаа, кадастрын болон байр зүйн зургийн шинэчлэлт	ОНХС	100,000.0	100,000.0
13	Харилцаа холбооны шилэн кабелийн сувагчлал	ОНХС	100,000.0	100,000.0
14	Цаг агаарт зориудаар нөлөөлөх, агаарын чанарын автомат станцын бодис	ОНХС	52,000.0	52,000.0
15	Ахмадын хорооны тоног төхөөрөмж /Улаангом сум/	ИЗХОТАХ	200,000.00	200,000.00
16	Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж /Хяргас сум/	ИЗХОТАХ	170,000.00	170,000.00
17	Ерөнхий боловсролын сургуулийн тоног төхөөрөмж /Зүүнхангай сум/	ИЗХОТАХ	80,000.00	80,000.00
18	Ахмадын төвийн тохижилт /Өндөрхангай сум/	ИЗХОТАХ	50,000.00	50,000.00
19	Хилийн цэргийн 0245-р ангид шаардлагатай засварын ажил	ИЗХОТАХ	80,000.00	80,000.00
20	Хилийн цэргийн 0311-р ангид шаардлагатай тоно төхөөрөмж	ИЗХОТАХ	60,000.00	60,000.00
21	ШШГГ-ын камержуулалт, засвар	ИЗХОТАХ	27,114.70	27,114.70
22	Яаралтай тусламжийн нэгдсэн 112 дугаарлалтыг нэвтрүүлэх ажил	ИЗХОТАХ	100,000.00	100,000.00
23	Айл өрхүүдийг "IP TV интернетийн сүлжээнд холбох /Бөхмөрөн сум/	ИЗХОТАХ	70,000.00	70,000.00
24	Цэцэрлэгийн тоглоом, хэрэгсэл /Бөхмөрөн сум/	ИЗХОТАХ	30,000.00	30,000.00
25	Сургуулийн засвар / Ховд сум /	ИЗХОТАХ	100,000.00	100,000.00
26	Ахмадын байр засвар /Цагаанхайрхан сум/	ИЗХОТАХ	50,000.00	50,000.00
27	Зөөврийн агуулах, камер /Цагаанхайрхан сум,/	ИЗХОТАХ	20,000.00	20,000.00
28	Соёлын төвийн өрөө тохижуулах, тоног төхөөрөмж /Цагаанхайрхан сум/	ИЗХОТАХ	30,000.00	30,000.00
29	Тохой, Баяннуур, Өгөөмөр баг чиглэлийн авто замын элстэй хэсгийг засварлах /Зүүнговь сум/	ИЗХОТАХ	100,000.00	100,000.00
Дүн			2,319,114.7	2,219,114.7

Эх сурвалж: Орон нутгийн 2026 оны төсвийн төсөв, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн тулгалт

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан Орон нутгийн хөгжлийн сан болон их засвар, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тусгагдсан 43 төсөл, арга хэмжээнээс зураг төсөвгүй, ТЭЗҮ, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт байхгүй, холбогдох зөвшөөрөл дутуу, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 29 төсөл, арга хэмжээг хасах саналтай байна.



Санал: 4. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийн хөтөлбөр төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан 1 төсөл, арга хэмжээний хөтөлбөр нь байхгүй байна.

/мянган.төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх/ дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжих	Тайлбар
1	Жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр	2026- 2026	20,000.0	20,000.0	Хөтөлбөр байхгүй

Эх сурвалж: Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан хөтөлбөргүй дээрх төсөл, арга хэмжээг хасах саналтай байна.

Санал: 5. Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын шинж чанартай Шинэ Улаангом захын барилгад дэмжлэг- 3,000.0 сая төгрөгийг урсгал зардлаар тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дахь заалтад "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг" гэж заасан байхад Шинэ Улаангом захын барилгад дэмжлэгт 3,000.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий дансанд урсгал зардлаар тусгасан байна.

Тухайн зардлыг хууль тогтоомжид нийцүүлэн хөрөнгийн зардалд шилжүүлэн тусгах.



БҮЛЭГ: 4. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ САНАЛ

Санал:1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Бизнес инкубатор төвийн барилгыг зориулалтын дагуу ашиглах замаар орон нутгийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/-2,300.0 сая төгрөгийн өртөгтэй 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр комисс хүлээн авсан ч 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар ашиглаж эхлээгүй байна.



Увс аймаг дахь Төрийн аудитын газраас Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар тухайн барилгыг зориулалтын дагуу ашиглах зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлсэн ч хэрэгжээгүй байна.

Тухайн барилга нь аймгийн ЗДТГ-ын данс бүртгэлд байх бөгөөд 2025 онд барилгын тогтмол зардлыг төсвөөс төлж байна. Үүнд:

2025 оны 10 сарын байдлаар төлсөн зардлын судалгаа

/мянган.төгрөг/

Д/д	Халаалтын зардал	Цахилгааны зардал	Цэвэр, бохир усны зардал
1	7,971.1	86.9	73.5
2	7,971.1	93.0	73.5
3	7,971.1	83.5	73.5
4	7,971.1	104.4	73.5
5	3,970.7	118.7	73.5
6		88.0	73.5
7		201.7	73.5
8		106.7	73.5
9	3,970.6	131.9	73.5
10	7,941.1	131.9	73.5
11			
12			
	47,766.8	1,146.7	735.0

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын тамгын газрын судалгаа



Дээрх судалгаанаас харахад 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 49.6 сая төгрөгийн зардал төлсөн байна.

Он дуустал буюу 11, 12 сарын төлбөрийг нэмж тооцоолж үзэхэд тухайн барилга ашиглалттай холбоотойгоор аймгийн ЗДТГ-ын төсвөөс 2025 онд **нийт 66.0 сая** төгрөг төлөхөөр байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй”, 2.1-д “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”, 2.2-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх”, 78 дугаар зүйлийн 2-д “Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 2.1-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах” гэж заасан байна.

Иймд тухайн барилгын ашиглалтыг хуулийн хүрээнд зохион байгуулж, ашиглалтыг оновчтой болгосноор төсвийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирч, төсвийн үр ашиг нэмэгдэх боломжтой байна.

Санал:2. Улсын төсвийн байгууллагуудын торгуулийн орлого Улсын төсөвт төвлөрч байгаа нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь заалттай нийцэхгүй байгаа асуудлыг шийдвэрлүүлэхээр салбар яаманд санал уламжилснаар орон нутгийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”, 23.3 дах хэсэгт “Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, **торгуулийн орлого**, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ” гэж заасан байна.

Торгууль ногдуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан торгуулийн орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж байна.



Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын судалгаа

/мянган.төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	2023 онд	2024 онд	2025 онд
1	Увс аймаг дахь Гаалийн газар	400.0	3,550.0	350.0
2	Улсын бүртгэлийн хэлтэс	9,300.0	11,250.0	5,550.0
3	Увс нуурын ай савын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа	500.0	-	-
4	Нийгмийн даатгалын газар	3,350.0	250.0	-
5	Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар	1,400.0	900.0	1,200.0
6	Эрүүл мэндийн газар	4,300.0	1,200.0	300,000
7	Хүнс, хөдөө аж ахуйн газар	3,000.0	3,500.0	7,500.0
8	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	6,000.0	4,000.0	2,000.0
9	Увс аймгийн Мал эмнэлгийн газар	500.0	4,350.0	5,050.0
10	Увс аймгийн Автотээврийн төв	3,990.0		6,785.0
Нийт		32,740.0	29,000.0	28,735.0

Эх сурвалж: Төсөвт байгууллагуудаас авсан судалгаа

Улс, орон нутгийн төсөвт 2023, 2024 онд нийтдээ 2,581.5 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрүүлснээс 2,519.8 сая төгрөг буюу 97.6 хувь нь орон нутгийн төсөвт, 61.7 сая төгрөг буюу 2.4 хувь нь улсын төсөвт төвлөрчээ.

Гэтэл Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.7.2 дахь заалтад “орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого”, 23.9 дэх хэсэгт “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ”, 23.9.2 дахь заалтад “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого” гэж заасан байна.

Улсын төсвийн байгууллагуудын торгуулийн орлого Улсын төсөвт төвлөрч байгаа нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь заалттай нийцэхгүй байгаа асуудлыг шийдвэрлүүлэхээр салбар яаманд санал уламжилснаар зөрчил гаргасан этгээдийн торгуулийн орлогыг тухайн зөрчил гаргасан нутаг дэвсгэрийн төсөвт төвлөрүүлэх боломжтой байна.



ДҮГНЭЛТ


Энэхүү аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.
2. Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, удирдамжийн дагуу орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулсан байна.
3. Орон нутгийн 2026 оны төсвийн нийт зарлагыг 89,313.7 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2025 оноос 12,656.1 сая төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн байна.
4. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийн суурь орлогыг Сангийн яамнаас 33,168.7 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг 8,483.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн төсөлд 41,652.6 сая төгрөгөөр тусгасан байна.
5. Орон нутгийн 2026 оны төсвийн зарлагыг 2,489.1 сая төгрөгөөр бууруулах боломж байна.
6. Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан 9,953.9 сая төгрөгийн хөрөнгийн зардлыг хэт жижиглэж 48 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн нь орон нутгийн тэргүүлэх чиглэл, хөгжлийн бодлогын шинж чанартай томоохон төсөл, арга хэмжээнүүд хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэж байна.
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Бизнес инкубатор төвийн барилгыг зориулалтын дагуу ашиглах замаар орон нутгийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.
8. Улсын төсвийн байгууллагуудын торгуулийн орлого Улсын төсөвт төвлөрч байгаа нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь заалттай нийцэхгүй байгаа асуудлыг шийдвэрлүүлэхээр салбар яаманд санал уламжилснаар орон нутгийн төсвийн үр ашгийг дээшлүүлэх боломж байна.

Хянасан: Аудитын менежер

Бэлтгэсэн: Ахлах аудитор

Аудитор



М.Бат-Амгалан

Т.Намжил

Ч.Мөнхтогтох

Т.Амармэнд

Б.Нямбуу

Т.Золоо

Т.Ариунсайхан

Л.Шагдарсүрэн

Увс аймаг, Улаангом-85160,
Засаг даргын тамгын газрын байр Утас:70453317
И-мэйл: uvs@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn